

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

Дараах тохиолдлуудыг уншаад 1-6 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Ангийн сонгууль	Өвлийн халтиргаа
Багш М ангийн хурал хийхдээ ангийн даргыг сонгох тухай санал асуулга явуулжээ. Ангийн сурагчид нэг нэгээрээ гараа өргөн ангийн даргыг сонгох тухай ээлж дараалан ярьж байхад сурагч П бусад сурагчдын санал бодлыг үл ойшоож, өөрийн сайн найз болох Б-г ангийн даргаар сонгох ёстой гэжээ.	Р ажил руугаа машинтай явж байгаад урд талд явж байсан машины араас мөргөжээ. Учир нь цас их орсон тул замд халтиргаа үүсэж машинаа тоормозолсон ч халтираад урд талын машиныг мөргөсөн байна. Харин мөргүүлсэн машины эзэн нөхцөл байдлыг ойлгож Р-тэй харилцан тохиролцжээ. Гэхдээ Р зам тээврийн осол гаргасан тул 50 нэгжээр торгуулжээ.
Австралийн уугуул иргэд	Шилжих хөдөлгөөн
Судлаач Г Австралийн уугуул иргэдийн шашин, зан заншил, баяр наадмын тухай судалгаа 2 жилийн турш хийсэн бөгөөд судалгааныхаа үр дүнг нийгмийн болон соёлын өөрчлөлттэй холбон тайлбарлажээ.	А-ын гэр бүл Улаанбаатар хотод ажиллаж амьдрахаар нүүж ирсэн бөгөөд цуглуулж, хадгалсан мөнгө нь байр авахад хүрэлцэхгүй байсан тул банкнаас 80 сая төгрөгийн зээл авч 2 өрөө байр худалдан авсан.

- Маслоугийн хүний хэрэгцээний шатлалын бие физиологийн хэрэгцээг аль тохиолдол нь илэрхийлж байна вэ? /1 оноо/
 А. Ангийн сонгууль
 В. Австралийн уугуул иргэд
 С. Өвлийн халтиргаа
 D. Шилжих хөдөлгөөн
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх хоёрдугаар алхмыг аль тохиолдол илэрхийлж байна вэ? /1 оноо/
 А. Ангийн сонгууль
 В. Австралийн уугуул иргэд
 С. Өвлийн халтиргаа
 D. Шилжих хөдөлгөөн
- Дээрх тохиолдлуудыг уншаад зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы загварын аль ойлголт үнэн эсэхийг тодорхойлоорой. /2 оноо/
 А. Ангийн сонгууль - Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы загварын “Сөргөлдөх”
 В. Австралийн уугуул иргэд - Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы загварын “Хамтран ажиллах”
 С. Өвлийн халтиргаа - Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы загварын “Зайлсхийх”
 D. Шилжих хөдөлгөөн - Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы загварын “Шүүхээр шийдүүлэх”

4. Дээрх дөрвөн тохиолдолд үзүүлсэн дүрслэлийг нэгтгэн тодорхойлоорой. /2 оноо/
- Хувь хүний хэрэгцээ болон хамтын ажиллагаа, зөрчилдөөн, түүнийг шийдвэрлэх алхам, хандлагуудын тухай
 - Сайн дурын үйл ажиллагаа болон зөрчилдөөн, түүнийг шийдвэрлэх алхам, хандлагуудын тухай
 - Хувь хүний хэрэгцээ, зөрчилдөөн, түүнийг шийдвэрлэх алхам, хандлагууд болон соёлын хэлбэрийн тухай
 - Соёлын ангиллын шалгуур болон хувь хүний хэрэгцээ, түүний тухай ойлголт хандлагуудын тухай
5. Оюуны соёлыг илэрхийлж байгаа тохиолдол аль нь вэ? /1 оноо/
- Ангийн сонгууль
 - Австралийн уугуул иргэд
 - Өвлийн халтиргаа
 - Шилжих хөдөлгөөн
6. Дараах тохиолдлуудын аль нь албан хэм хэмжээг алдаатай тодорхойлсон байна вэ? /2 оноо/
- Ангийн сонгууль – ангийн хурал (ангийн даргыг сонгохдоо нээлттэй буюу сурагч бүр өөрийн санал бодлоо хэлж сонгосон) хийх нь сургуулийн болон ангийн дүрэм, журамд үндэслэсэн тул албан хэм хэмжээнд хамаарагдана.
 - Австралийн уугуул иргэд - Австралийн уугуул иргэдийн шашин, зан заншил, баяр наадмын тухай судалгааг нийгмийн болон соёлын өөрчлөлттэй холбон тайлбарласан тул энэ нь албан хэм хэмжээнд хамаарагдана.
 - Өвлийн халтиргаа - Р ажил руугаа машинтай явж байгаад урд талд явж байсан машины араас мөргөж зам тээврийн осол гаргасан 50 нэгжээр торгуулсан. 50 нэгжээр торгуулах нь албан хэм хэмжээнд хамаарагдана.
 - А-ын гэр бүл байр авахын тулд банкнаас 80 сая төгрөгийн зээл авсан. Банкнаас зээл авах нь мэдээж хууль, дүрэм, журамд үндэслэж зээл олгодог тул энэхүү үйлдэл нь албан хэм хэмжээнд хамаарагдана.
7. Соёлын өөрчлөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн жишээг олоорой. /2 оноо/

- Хиймэл оюун ухаанаар удирдуулсан гар бүхий роботууд хиймэл эд, эрхтний үйлдвэрлэлийг хариуцан төлөвлөлт, үйлдвэрлэл зэрэг бүх ажлыг гардан хийх болжээ.
- Судлаач Д-ын баг археологийн хайгуул, малтлага хийж байхдаа амьтны дүрсийг өвөрмөц байдлаар төмөр эдлэл болон чулуун хөшөөн дээр дүрсэлсэн олдвор олжээ.
- “Midsummer” буюу зуны хамгийн урт өдөр, богино шөнийг тэмдэглэдэг баяр өдгөө дэлхийн олон оронд ямар нэгэн байдлаар тэмдэглэгддэг ч гэлээ угтаа бол Скандиновын орнуудаас гаралтай ажээ.
- Баярбаатар хаана ч явсан бусдыг хүндэтгэх, бусадтай зөв ойлголцох арга чадвартай бөгөөд энэ нь түүний үнэт зүйл нь болж байдаг.

A. 1, 2

B. 3, 4

C. 1, 3

D. 2, 4

8. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү. /1 оноо/
- нь тухайн орон нутгийн хүн ам, баялаг бүтээх, орон нутгаа хөгжүүлэх тухай багц асуудлыг багтаана. Тухайлбал: Хүн ам, эдийн засгийн бүтэц, аж ахуй эрхлэлт
- Эдийн засаг
 - Орон нутгийн эдийн засаг
 - Орон нутаг
 - Үйлдвэрлэл

9. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү. /1 оноо/
Тухайн зах зээлд нийлүүлэх хүсэл эрмэлзэлтэй бөгөөд үйлдвэрлэх боломжтой бараа үйлчилгээний тоо хэмжээг гэнэ.
А. Эрэлт В. Нийлүүлэлт С. Зах зээлийн тэнцвэрт үнэ D. Үнэ

10. Хүснэгтэд байгаа байгууллагын үйл ажиллагааны онцлогийг ажиглаад аль байгууллагын онцлогийн ямар баганад алдаа байгааг тодорхойлно уу. /2 оноо/

Үйл ажиллагааны онцлог	1-р багана	2-р багана
Төрийн байгууллага	Төрийн үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэж байдаг.	Төсвөөс санхүүждэг байгууллага (засаг даргын тамгын газар)
Төрийн бус байгууллага	Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр нэгдсэн.	Төрөөс хараат байгууллага (залуучуудын холбоо)
Аж ахуйн нэгж	Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд орно.	Төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч мөн.


- A. Аж ахуйн нэгжийн 1-р багана; Төрийн бус байгууллагын 1-р багана
B. Төрийн байгууллагын 2-р багана; Төрийн бус байгууллагын 1-р багана
C. Төрийн бус байгууллагын 2-р багана; Аж ахуйн нэгжийн 2-р багана
D. Аж ахуйн нэгжийн 2-р багана; Төрийн бус байгууллагын 1-р багана
11. Бизнесийн төлөвлөгөөний бүтэц, үе шатын нэг болох “Бизнесийн зорилго” хэсэгт хамаарч буй ойлголтыг олоорой. /2 оноо/

- | | |
|------------------------------|------------------------------|
| 1. Бизнесийн хэлбэр, байршил | 2. Ажиллах хүч, бүтэц |
| 3. Үр ашиг, татвар | 4. Бүтээгдэхүүний тоо хэмжээ |
| 5. Борлуулалтын орлого | 6. Бизнесийн хүрэх үр дүн |

- A. 3, 5 B. 2, 4 C. 1, 6 D. 1, 3

12. Дараах графикийг анхааралтай ажиглаад, асуултад хариулаарай.

/2 оноо/



Асуулт: Доорх хүснэгтэд байгаа өгөгдлүүдийг ашиглаж эрэлт, нийлүүлэлтийн харилцан хамаарлыг тооцоолон хомсдолыг олоорой.

P- Үнэ

Q-тоо хэмжээ

Бодлого №1

Үнэ	Эрэлт	Нийлүүлэлт	Илүүдэл/Хомсдол
7000			

- A. Эрэлт 45000, нийлүүлэлт 25000 болж 20000 ширхэг бүтээгдэхүүний хомсдол бий болно.
 B. Эрэлт 25000, нийлүүлэлт 45000 болж 20000 ширхэг бүтээгдэхүүний хомсдол бий болно.
 C. Эрэлт 45000, нийлүүлэлт 25000 болж 4000 ширхэг бүтээгдэхүүний хомсдол бий болно.
 D. Эрэлт 25000, нийлүүлэлт 45000 болж 4000 ширхэг бүтээгдэхүүний хомсдол бий болно.

13. Ямарваа нэгэн асуудлаар улс орнуудыг тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг уриалсан олон улсын эрх зүйн баримт бичгийн нэг төрөл аль нь вэ? /1 оноо/

- A. Пакт
 B. Тунхаглал
 C. Үндсэн хууль
 D. Протокол

14. “Бусдаас хүсээж буй зүйлээ өөрөө бусдад хандуулан үйлд, бусдаас хүсэхгүй зүйлээ бусдад хандан бүү үйлд” хэмээн ёс суртахууны алтан зарчмыг тодорхойлсон нь хүний эрхийн үндсэн зарчмуудыг агуулсан гэж үздэг. Энэ нь дараах өгөгдлүүдийн алинд нь хамаарч байна вэ? /1 оноо/

- A. Вавилон улсын Хаммураби хааны хууль
 B. “Магна Харта” хэмээх тунхаг бичиг
 C. АНУ-ын “Тусгаар тогтносон тунхаглал”
 D. Күнзийн сургаал

15. Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүргийг аль нь зөв тодорхойлсон байна вэ? /1 оноо/

- A. Хамгаалах; Ахиц дэвшил; Хүндэтгэх; Хангах
 B. Байгалиа хамгаалах; Хөдөлмөрлөх; Эрүүл мэндээ хамгаалах; Үр хүүхдээ хүмүүжүүлэх
 C. Эх орноо хамгаалах; Үндсэн хуулиа дээдлэх; Хүний нэр төрийг хүндэтгэх; Татвар төлөх
 D. Хариуцлага хүлээх; Хуваагдашгүй байх; Харилцан хамааралтай байх; Салшгүй байх

16. Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактад баталгаажуулсан эрхүүдэд хамаарахыг сонгоорой. /2 оноо/

1. Амьжиргааны зохистой түвшинд амьдрах эрх
 2. Хуулийн өмнө тэгш байх эрх
 3. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх
 4. Нийгэм, соёлын амьдралд оролцох эрх

A. 1, 3

B. 3, 4

C. 2, 4

D. 2, 3

17. Хүснэгтэд байгаа хүмүүс хоорондын ялгаатай байдлын жишээг ажиглаад аль ойлголтын жишээний ямар баганад алдаа байгааг тодорхойлно уу. /2 оноо/

Хүмүүс хоорондын ялгаатай байдал	1-р багана	2-р багана	3-р багана
Төрөлхийн ялгарал	Улаанаа Улаанбаатар хотод шилжиж ирээд ангийнхаа сурагчидтай тоглож байгаад күүкдүүд ээ наарийч наарийч гэж дуудсанаас болоод сурагчид түүнийг “Наарийч Улаанаа гэдэг болжээ.	Д “Нийгэм судлал”-ын хичээлийн гэрийн даалгавраа цаг тухайд нь багшдаа үзүүлдэг. Гэтэл Д-н гэрийн даалгавраа хийсэн хичээлийн дэвтрийг ангийн хүүхдүүд нь нууцаар авч урсан тохиолдол гарчээ.	Би 19 настай 2-р курсийн оюутан. Намайг 1-р курст ороход манай ангид 45 настай ах орж ирээд нэг жил сураад сургуулиас гарсан. Яагаад гэвэл зарим оюутнууд тэр ахыг хөгшин байж одоо сураад хэрэг байна уу хэмээн байнга тоглодог байсан.
Төрөлхийн бус ялгарал	С ажилдаа өдөр бүр хамгийн түрүүлж очдог бөгөөд ур чадварын хувьд ч тэр бусдад хүлээн зөвшөөрөгдсөн. Харин англи хэлний мэдлэггүйгээс нь болж ажлынхан нь гадуурхаж эхэлжээ.	Ц “Нийгэм судлал”-ын багш мэргэжлээр дөнгөж сургуулиа төгсөөд багшлах гэтэл ихэнх сургуулиуд ажлын туршлага шаардлагатай тул ажилд авах боломжгүй гэжээ.	Дорж шуурхай албаны хамгаалагч ажилд авна гэсэн зар мэдээ уншаад ажилд орохоор очтол тухайн байгууллага нь 25-40 насны болон 175см дээш өндөртэй хүн ажилд авна гэсэн шаардлагатай байсан тулд ажилд орж чадаагүй байна.

- A. Төрөлхийн ялгарал 2-р багана; Төрөлхийн бус ялгарал 3-р багана
B. Төрөлхийн ялгарал 2-р багана; Төрөлхийн бус ялгарал 1-р багана
C. Төрөлхийн ялгарал 1-р багана; Төрөлхийн бус ялгарал 2-р багана
D. Төрөлхийн ялгарал 3-р багана; Төрөлхийн бус ялгарал 3-р багана

18. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү. /1 оноо/

Тодорхой нутаг дэвсгэрт аж төрөн суугаа хүмүүс, тэдний төлөөлөл өөрсдийн амьдрал аж ахуйд хамаатай бүхий л асуудлыг орон нутгийнхаа санхүү эдийн засгийн боломждоо тулгуурлан хууль тогтоомжийн хүрээнд хамтран шийдвэрлэх эрх мэдлийг гэдэг.

- A. Орон нутгийн нийгмийн орчин
B. Хамтын удирдлага
C. Төр
D. Нутгийн өөрөө удирдах ёс

19. Өөрийн орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг иргэд өөрсдөө эсвэл тэдний төлөөлөл хэлэлцэж шийдвэрлэснээр давуу талуудтай. Үүнд үл хамаарч буй ойлголтыг олоорой. /1 оноо/

- A. Энх тайван, шударга ёсноос ангид байна.
B. Орон нутгийн хөгжилд нааштай үр нөлөөтэй.
C. Ардчилал болон эрх, эрх чөлөө улам бэхэжнэ.
D. Иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ ойрхон болно

20. Орон нутгийн удирдлага хэрхэн бүрддэг вэ? Өгөгдлийг ашиглаж бүдүүвчийг гүйцээгээрэй.

/2 оноо/

